



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 5/25

Чингис хот

Б.Мөнхжаргалыг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.3, 3.3.4, 4.3, 4.3.3, 4.4 дэх заалт, 2014 оны 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Бөхчулууны Мөнхжаргалыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2017 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

Хоёр. Б.Мөнхжаргалын үндсэн цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоож 509948 /таван зуун есөн мянга есөн зуун дөчин найман/ төгрөгөөр тооцон олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ч.Болормаа	-Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Л.Очирмаа	-Аж ахуйн нярав

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Мөнхжаргалд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

